

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ ДҮГНЭЛТ ГАРГАХ”
НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/06-ШТА-НА

Чойбалсан хот 2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
Аудитор М.Ганбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ganbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
Ерөнхий мэдээлэл.....	5
Бүлэг 1. Сонгуулийн хороодод төсвийг хууль журмын дагуу төлөвлөж хуваарилсан байна.....	6
1.1.1 Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийг зохион байгуулах зардлын төсвийг журмын дагуу боловсруулж батлуулсан байна.....	6
1.1.2 Аймгийн Сонгуулийн хорооноос сумын Сонгуулийн хороодод төсвийг журмын дагуу хуваарилсан байна.....	7
1.1.3 Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой төсвийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас бодитой тооцож ирүүлээгүй байна.....	7-8
Бүлэг 2. Зардлыг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.....	9
1.2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.....	9
1.2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.....	10
1.2.3 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.....	10
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....	11
ДҮГНЭЛТ:	11
САНАЛ:	11
ЗӨВЛӨМЖ:	11
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	12

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ШТА	Шууд тайлагналын аудит
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
МТБ	Мэдээлэл технологийн баг

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁОГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төсвийн төсөл, батлагдсан төсөв зардлын ангиллаар.	6
Хүснэгт 2	Сумын сонгуулийн хороодод хуваарилсан төсөв.	7
Хүснэгт 3	Цагдаагийн газрын зарцуулсан төсөв, гүйцэтгэл.	8
Хүснэгт 4	Улсын бүртгэлийн хэлтсийн зарцуулсан төсөв, гүйцэтгэл	8
Хүснэгт 5	Батлагдсан төсөв, гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар.	9

	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн хийлээ.
Аудитын зорилт	Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг Үндэсний аудитын газар, бусад байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Энэхүү зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Улсын Их Хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх; • Улсын Их Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймаг, сумын сонгуулийн хороод, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс болон холбогдох бусад байгууллагуудыг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, Нийцлийн болон Санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг, М.Ганбилэг нар хийж гүйцэтгэлээ. Аудитын талбарын ажлыг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс эхлүүлж, тайланг ҮАГ-ын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар болон аймгийн Сонгуулийн хороонд 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдөр хүргүүлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгууль зохион байгуулах аймаг, нийслэлийн сонгуулийн хороог Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 23 дугаар тогтоолоор байгуулсан байна. Уг тогтоолд Дорнод аймгийн Сонгуулийн хороог сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, 7 гишүүдтэй нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байхаар заасан байна.

УИХ-ын 2024 оны сонгуулийг 75 хэсгийн хороодтой зохион байгуулж, тэдгээрт ажиллах 639 төрийн албан хаагч ажилтан томилогдон ажилласан байна.

УИХ-ын 2024 оны сонгуульд санал өгөх сонгогчийн нэрийн жагсаалтад 51,930 сонгогч бүртгэлтэй байгаагаас санал хураалтад нийт 33,921 сонгогч буюу иргэдийн 65.3 хувь нь саналаа өгсөн байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос Дорнод аймгийн Сонгуулийн хороонд нам эвсэл, нэр дэвшигчийн 133,338 ширхэг саналын хуудас олгосноос 69,388 ширхэг буюу 52 хувь нь санал хураалтад зарцуулагдаж, 63,950 ширхэг саналын хуудас зарцуулагдаагүй үлдсэн байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны тамгын газрын даргын 2024 оны А/45 дугаартай тушаалын нэгдүгээр хавсралтаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн Дорнод аймгийн сонгуулийн хорооны төсвийг 769.3 сая төгрөгөөр баталсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос дээрх төсвийг аймгийн Сонгуулийн хороонд бүрэн олгосон байна

Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь батлагдсан төсвөөс 768.6 сая төгрөгийг зарцуулж 0.6 сая төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлжээ.

Бүлэг 1. Сонгуулийн хороодод төсвийг хууль журмын дагуу төлөвлөж хуваарилсан байна.

1.1.1 Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийг зохион байгуулах зардлын төсвийг журмын дагуу боловсруулж батлуулсан байна.

Дорнод аймгийн Сонгуулийн хорооноос Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийг зохион байгуулах зардлын төсвийн төслийг 769.3 сая төгрөгөөр тооцож Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлсэн байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны тамгын газрын даргын 2024 оны А/45 дугаартай тушаалын нэгдүгээр хавсралтаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн Дорнод аймгийн сонгуулийн хорооны төсвийг 769.3 сая төгрөгөөр баталсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос дээрх төсвийг аймгийн Сонгуулийн хороонд бүрэн олгосон байна.

Хүснэгт 1. Төсвийн төсөл, батлагдсан төсөв зардлын ангиллаар.

/мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	300.0	300.0	-
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	42,284.0	42,284.0	-
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	2,130.0	2,130.0	-
4	Дүн мэдээ дамжуулах зардал	1,300.0	1,300.0	-
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	23,250.0	23,250.0	-
6	Сургалт, сурталчилгааны зардал	32,279.0	32,279.0	-
7	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээлэл технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	562,104.0	562,104.0	-
8	Бичиг хэргийн зардал	12,100.0	12,100.0	-
9	Шуудан холбооны зардал	14,350.0	14,350.0	-
10	Унааны зардал	61,810.0	61,810.0	-
11	Албан томилолтын зардал	10,184.0	10,184.0	-
12	Болзошгүй зардал	7,200.0	7,200.0	-
ДҮН		769,291.0	769,291.0	-

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны төсвийн төсөл, батлагдсан төсөв.

Монгол улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-

ний өдийн А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-д заасны дагуу төсвийг боловсруулсан байна.

1.1.2 Аймгийн Сонгуулийн хорооноос сумын Сонгуулийн хороодод төсвийг журмын дагуу хуваарилсан байна.

Дорнод аймгийн Сонгуулийн хорооны 2024 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 03 дугаар тогтоолоор сумын сонгуулийн хороодод төсөв хуваарилсан байна.

Хүснэгт 2. Сумын сонгуулийн хороодод хуваарилсан төсөв.

/мянган төгрөгөөр/				
д/д	Сумын нэр	Аймгаас сумдад хуваарилсан төсөв	Аудитаар тооцсон төсөв	Зөрүү
1	Баяндун	34,697.8	34,697.8	-
2	Баянтүмэн	37,615.8	37,615.8	-
3	Баян-Уул	45,734.4	45,734.4	-
4	Булган	32,175.8	32,175.8	-
5	Гурванзагал	30,727.2	30,727.2	-
6	Дашбалбар	46,290.4	46,290.4	-
7	Матад	48,393.0	48,393.0	-
8	Сэргэлэн	44,938.6	44,938.6	-
9	Халхгол	39,462.6	39,462.6	-
10	Хөлөнбуйр	30,540.6	30,540.6	-
11	Цагаан-овоо	53,197.0	53,197.0	-
12	Чойбалсан	37,799.0	37,799.0	-
13	Чулуунхороот	31,575.2	31,575.2	-
14	Хэрлэн	136,375.4	136,375.4	-
		649,522.8	649,522.8	-
	Аймаг	119,768.2	119,768.2	-
	Дүн	769,291.0	769,291.0	-

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны даргын 03 тоот тушаал.

Монгол улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.3-т заасан зардлуудад аймгийн сонгуулийн хорооноос сумын сонгуулийн хороодод төсөв хуваарилсан байна.

1.1.3 Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой төсвийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас бодитой тооцож ирүүлээгүй байна.

1. Цагдаагийн ерөнхий газрын санхүү, ар талын албаны 2024 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 16/1983 тоот албан бичгээр Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтын зардлын төсвийг баталсан байна.

Аудитаар давтан тооцож үзэхэд Дорнод аймаг дахь Цагдаагийн газар нь Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтын зардлын төсвийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Хүснэгт 3. Цагдаагийн газрын зарцуулсан төсөв, гүйцэтгэл.

/мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү
1	Хоолны зардал	26,928.0	26,928.0	-
2	Шуудан холбооны зардал	11,170.0	11,170.0	-
3	Шатахууны зардал	2,000.0	2,000.0	-
Дүн		40,098.0	40,098.0	

Эх сурвалж: Дорнод аймаг дахь Цагдаагийн газар, сонгуулийн зардлын судалгаа.

Дорнод аймаг дахь Цагдаагийн газар нь Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтын зардлын төсвийн зарцуулалтын тайланг 2024 оны 7 дугаар сарын 01-ний 39/1863 Цагдаагийн ерөнхий газрын санхүү, ар талын албанд хүргүүлсэн байна.

2. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгууль зохион байгуулах зардлын төсвийг баталсан байна. Тушаалын хавсралтаар Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст дараах 4 зардалд нийт 72.9 сая төгрөгийн төсөв хуваарилсан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн А/104 дүгээр тушаалаар тоног төхөөрөмжийн туршилтыг орон нутагт хийхэд шаардагдах зардлын төсвийг баталсан байна. Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 4.1 сая төгрөгийн төсөв хуваарилсан байна.

Хүснэгт 4. Улсын бүртгэлийн хэлтсийн зарцуулсан төсөв, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү
1	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардал	48,150.0	48,773.4	-623.4
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэхэд шаардагдах зардлын төсөв	5,106.9	5,355.2	-248.3
3	Сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардлын төсөв	11,712.0	10,129.9	1,582.1
4	Сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардлын төсөв	7,936.0	8,946.4	-1,010.4
Дүн		72,904.9	73,204.9	300.0
1	Тоног төхөөрөмж туршилтыг орон нутагт хийхэд шаардагдах зардлын төсөв	4,120.0	3,820.0	300.0
Нийт дүн		77,024.9	77,024.9	-

Эх сурвалж: Улсын бүртгэлийн хэлтэс, сонгуулийн зардлын судалгаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газар Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгууль зохион байгуулах зардлын төсвийн төслийн саналыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс аваагүй байна.

Томилолтын зардал хүрээгүйгээс сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардлын төсвөөс 1.6 сая төгрөгийг бусад зардалд шилжүүлэн зарцуулсан байна.

Бүлэг 2. Зардлыг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

1.2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны тамгын газрын 2024 оны 3/229, 3/290, 3/373, 3/472, 3/562 тоот албан бичгээр ирүүлсэн төсвийн зарцуулалтын тайлбарт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийг зохион байгуулах зардлыг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 5. Батлагдсан төсөв, гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар.

/мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	300.0	300.0
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	42,284.0	42,284.0
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	2,130.0	2,130.0
4	Дүн мэдээ дамжуулах зардал	1,300.0	1,300.0
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	23,250.0	23,250.0
6	Сургалт, сурталчилгааны зардал	32,279.0	32,279.0
7	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээлэл технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	562,104.0	561,438.0
8	Бичиг хэргийн зардал	12,100.0	12,100.0
9	Шуудан холбооны зардал	14,350.0	14,350.0
10	Унааны зардал	61,810.0	61,810.0
11	Албан томилолтын зардал	10,184.0	10,184.0
12	Болзошгүй зардал	7,200.0	7,200.0
Дүн		769,291.0	768,625.0

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл.

Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь батлагдсан төсвөөс 768.6 сая төгрөгийг зарцуулж 0.6 сая төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлжээ.

Сонгуулийн хороодын зардлын зарцуулалтыг төсвийн гүйцэтгэлийн мэдээ, дансны хуулга, анхан шатны баримтуудтай тулган шалгахад хууль, журмын дагуу зарцуулсан байна.

1.2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

Аймаг, сумын Сонгуулийн хороод нь Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдийн А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтаар сонгуулийн зардлын тайлангаа гаргасан байна.

Аудитаар зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан эсэхийг эдийн засгийн ангиллаар тулган шалгахад зөрүү гараагүй.

Хэрлэн, Халхгол, Сэргэлэн, Чулуунхороот сумаас бусад сумдын сонгуулийн хороод сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалаа аймгийн сонгуулийн хороонд албан бичиггүй өгсөн байна. “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 1 дүгээр хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.3.1-т “Сонгуулийн зардлын тайлан өгөх тухай албан бичиг” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

1.2.3 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Сонгуулийн хороодод нэгдсэн журмаар төрийн санд түр данс нээсэн байна. Сонгуулийн хороодын зардлын гүйлгээнд аймаг, сумын төрийн сангаас хяналт тавьж ажилласан байна.

Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч Ц.Амгаланзаяа нь Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдийн А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-д заасан санхүү, эдийн засгийн бакалавр, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан, санхүүгийн тайлан гаргах чадвартай байх гэсэн шалгуурыг хангасан байна.

Сонгуулийн хорооны дарга сонгуулийн хорооны зардлын гүйлгээний баримт дээр нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч хоёрдугаар гарын үсгийг зурж ажилласан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороонд зардлын санхүүжилт, гүйцэтгэлд аргачлал, зөвлөмж, чиглэлийг тухай бүр өгч хяналтыг тавьж ажилласан байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:


**ДОРНОД АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**
Чойбалсан, Дорнод аймаг, 21000
Утас/ факс: 7058-4681

Б.Бат-Мөнх
Аудитын танилцаж
Батгалсан

2024.07.17 № 49

танай _____-ны № _____-Т

Б.Болортуул
Аудитор

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгууль зохион байгуулахтай холбогдсон аймгийн Сонгуулийн хорооны улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах нийцлийн аудитын тайлантай танилцлаа.

Төрийн Аудитын газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно .

ДАРГА  П.БАТ-ӨЛЗИЙ

C/Data;A5

210004083

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймаг, сумын Сонгуулийн хороодод төсвийг хууль журмын дагуу төлөвлөж хуваарилсан байна.
2. Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой төсвийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас бодитой тооцож ирүүлээгүй байна.
3. Аймаг, сумын сонгуулийн хорооны зардлыг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.
4. Сумын сонгуулийн хороод нь сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалаа аймгийн сонгуулийн хороонд журамд заасан албан бичиггүй ирүүлсэн байна.

САНАЛ:

Үндэсний аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах санал. Үүнд:

1. Улсын бүртгэлийн ерөнхий газар УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулах зардлын төсвийн төлөвлөлтийг бодитой хийгээгүй байна. (Аудитын тайлангийн 8 дугаар хуудас)

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмжийг өгч байна.

Дорнод аймгийн сонгуулийн хороонд:

1. Сумын сонгуулийн хороодын тайлангийн баримтын бүрдлийг бүрэн хангах.

Аудитаар ҮАГ-т нэгдсэн тайланд тусгуулах санал 1, зөвлөмж 1 өгч ажиллаа.

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 07 дугаар сарын 28-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/11

Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргах"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аймгийн Сонгуулийн хорооны дарга П.Бат-Өлзий нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Батжаргалд даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010166

ДОРНОД АЙМАГ, ХЭРЛЭН СУМ, 7-Р БАГ АЙМГИЙН ЗДТГ-ЫН БАЙР
УТАС: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-МЭЙЛ: DORNOD@AUDIT.GOV.MN , ВЕБ САЙТ: WWW.AUDIT.MN